



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 24-өөс
30-ны байдлаар

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 24-30-ны байдлаар

КОВИД-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн гаргаж буй гадаад орчны тойм мэдээллийн долоо дахь дугаарыг хүргэж байгааг хүлээн авна уу.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Moody's агентлаг **дэлхийн эдийн засаг 2020 онд 4.2 хувиар агших** суурь төсөөллийг 4-р сарын 27-нд зарлалаа¹. Уг төсөөлөлд АНУ-ын эдийн засаг 5.8 хувиар, Евро бүсийн эдийн засаг 7.0 хувиар, Их Британийн эдийн засаг 5.7 хувиар, Хятадын эдийн засаг 1.0 хувиар тус тус агшихаар тооцжээ. Суурь төсөөлөлд КОВИД-19-ийн тархалт 5-р сард оргилдоо хүрч, 7-р сараас намжих, дэлхий нийтээр 10-15 сая хүн КОВИД-19-өөр өвчлөх таамаглалт нөхцөлийг авч үзжээ.
- НҮБ-аас КОВИД-19 цар тахлын улмаас **дэлхий нийтэд ажиллах цаг 2020 оны 2-р улиралд вирусийн өмнөх үеэс (2019 оны 4-р улирлаас) 10.5 хувиар буурах** буюу **305 сая ажлын байр алдагдсантай тэнцэхээр байна** гэсэн тооцооллыг 4-р сарын 29-нд гаргав². Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас КОВИД-19-өөс үүдэлтэй хямралын эхний сард дэлхий нийтэд албан бус секторын ажилчдын орлого 60 хувиар буурсан, цаашид хөл хорио үргэлжлэх тохиолдолд албан бус секторын 1.6 тэрбум ажилчид ядууралд орох эрсдэлтэйг анхаарууллаа.
- **Герман, Франц, Их Британи, Итали, Испани** зэрэг **5 оронд цар тахлын улмаас нийт 30 сая гаруй ажилчид ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт гаргажээ**. Харин АНУ-д хөл хорио тогтоосноос хойш ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо **26 саяд хүрээд** байна. Европт КОВИД-19 цар тахлын улмаас ажилгүй болсон хүмүүст цалингийн 60 хүртэлх хувийг улсаас олгох хөтөлбөрийг цар тахал намжих хүртэл үргэлжлүүлэхэд дээрх 5 улсад хамгийн багадаа 100 тэрбум евро зарцуулна гэж тооцож байна.
- **АНУ-ын эдийн засаг 2020 оны 1-р улиралд урьдчилсан гүйцэтгэлээр 4.8 хувиар агшжээ³**. Энэ нь шинжээчдийн төсөөллөөс ихээр буурсан үзүүлэлт бөгөөд 2008 оноос хойш хамгийн огцом уналт юм. ДНБ ийнхүү агшихад өрхийн хэрэглээ 7.9 хувиар багассан, хөрөнгө оруулалт буурсан нь голлон нөлөөлөв. Энэ оны 2-р улиралд эдийн засаг өмнөх

¹ Энэ нь 3-р сард хийсэн суурь төсөөллөөс 6.1 нэгж хувиар буурсан төсөөлөл юм.

² НҮБ-аас 2 долоо хоногийн өмнө нийт 195 сая ажлын байр буурахаар тооцож байсан нь хөл

хорио удааширсантай холбоотойгоор ийнхүү нэмэгджээ.

³ АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний хороо (BEA)-оос 4-р сарын 29-нд зарласан статистик.

улирлаас ихээр агших, оны сүүлийн хагаст эргээд сэргэх төлөвтэй гэж Цагаан ордны эдийн засагч Larry Kudlow мэдэгдлээ.

- **Евро бүсийн эдийн засаг 2020 оны 1-р улиралд 4.8 хувиар агшина** гэж Блүүмбергийн шинжээчид таамаглаж байна. Европын холбооноос эдийн засгийн хүндрэлийн үед зээл олголтыг 450 тэрбум евро хүртэл нэмэгдүүлэх хэмжээнд банкны эх үүсвэрийг чөлөөлөх тухай саналыг хэлэлцэж байна. **Францын ДНБ 1-р улиралд 5.8 хувиар, Испанийн ДНБ 5.2 хувиар, Италийн ДНБ 4.7 хувиар** агшсан нь түүхэн дээд уналтууд болов.
- **Европын орнуудын эдийн засгийн үзүүлэлтүүд зарим үйл ажиллагаа аажим сэргэж эхэлснийг харуулж байна.** Тухайлбал, Цахилгаан эрчим хүчний хэрэглээ Испани болон Итали улсад 4-р сарын дундаас эхлэн сэргэж эхэлсэн байна. Google-ийн гэр, ажлын байр, үйлдвэр хоорондын шилжих хөдөлгөөний индексээс харахад Герман болон Испанид ажилчид эргэн ажилдаа орсон шинж тэмдэг илрээд байна⁴. Жижиглэнгийн худалдаа, тээвэр, үзвэр үйлчилгээ, орон байр, хоолны үйлчилгээ зэрэг үйлчилгээний салбаруудад сэргэлт харахан ажиглагдаагүй байна.
- **ОХУ-ын төв банк 4-р сарын 24-ны өдөр бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар бууруулж 5.5 хувь болголоо.** Дотоод эрэлт суларч, газрын тосны үнэ буурснаар инфляци өсөх дарамт багасч, мөнгөний бодлогоор эдийн засгийг дэмжих орон зай бий болсон гэж Төв банк үзжээ. Бодлогын хүүг бууруулах нь эдийн засгийг дэмжих хэдий ч, рублийн ханш сулрах дарамтыг нэмэгдүүлэх хүлээлттэй байгааг онцолжээ. ОХУ-ын төв банкны тэргүүн Э.Набиуллина

⁴ Жишээ нь Германд хүмүүсийн ажилдаа явсан хөдөлгөөн цар тахлаас өмнөх үеэс 43 хувиар бага

"Цаашид бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах боломжтой" гэж мэдэгдлээ. **ОХУ-ын эдийн засаг энэ онд 4-6 хувиар агшина гэж төв банк нь тооцоолж байна.** Мөн "Урал" төрлийн газрын тосны үнэ 2020 онд баррель тутамдаа дунджаар 27 ам.доллар байна, харин урсгал дансны алдагдал ДНБ-ий 7 хувь, нийт төсвийн алдагдал ДНБ-ий 6 хувьтай дүйцнэ гэж ОХУ-ын төв банк төсөөлж байна.

- **АНУ-ын Холбооны Нөөцийн банк (ХНБ) 4-р сарын 28, 29-нд хуралдаж ХНБ-ны хүүг 0-0.25 хувьд хэвээр хадгалах, КОВИД-19 цар тахлаас улмаас санхүүгийн хүндрэлд орсон муж, орон нутгийн захиргаанд олгох зээлийн сангийн хөрөнгийг 500 тэрбум ам.доллараар нэмэгдүүллээ.** 4-р сарын эхээр анх байгуулагдсан энэхүү санд нийт 4 их наяд ам.долларыг 24 хүртэлх сарын хугацаатайгаар муж орон нутгийн захиргаанд зээл олгоход төсөвлөжээ. Харин одоо зээлийн сангийн дүн нэмэгдсэний зэрэгцээ зээлийн эргэн төлөлтийн хугацааг 36 сар хүртэл сунгаж, хүн амын тоо багатай хот, мужууд хамрагдах боломжтой болгожээ. ХНБ цаашид мөнгөний бодлогын төлөвийг сул хэвээр хадгална гэж мэдэгдлээ. Эдийн засгийн сорилтын энэ цаг үед бодлогын бүх хэрэгслээ ашиглах болно гэж ХНБ-ны тэргүүн Жером Повел мэдэгдэлдээ онцлов.
- **Японы Төв банк Засгийн газрын бондын худалдан авалтын жилийн дээд хязгаар 80 их наяд иен байсныг цуцалж, хөрөнгө худалдан авалтыг нэмэгдүүлэх шийдвэрийг 4-р сарын 27-нд зарлалаа.** Ингэснээр 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж 0 орчим хувьд ирж байна. Мөн Японы засгийн газар нь төв банкнаас зээл авах хязгаарлалтгүйгээр эдийн

байгаа бол Итали, Испани, Франци, Их Британи зэрэг улсад 63-аас 68 хувиар буурчээ.

засгийг дэмжих бодлогууд хэрэгжүүлэх боломжтой боллоо. Төв банкны эзэмших хувийн секторын бондын дээд хязгаарыг

20 их наяд иен болгож, 2 дахин өсгөв. Мөн орон нутгийн банкуудад яаралтай, хөнгөлөлттэй зээл олгох хөтөлбөр хэрэгжүүлэх болов.

2 ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **Хятадын эдийн засаг 4-р сарын 20-ны байдлаар 91 хувийн потенциал түвшинтэйгээр ажиллаж байна.** 4-р сарын 14-ний байдлаар жилийн 20 сая юанийн орлоготой том аж ахуйн нэгжүүдийн 99 хувь, нийт ажилчдын 94 хувь нь ажилдаа эргэн ороод байна. Амралтын өдрүүдэд олон нийтийн идэвхжил 4-р сарын 11-ний өдрийн 73.8 хувиас 4-р сарын 18-ний байдлаар 77.2 хувь хүрч нэмэгдлээ. Энэ нь дотоод эрэлтийг дэмжих боломжтой гэж Блүүмбергийн шинжээчид дүгнэж байна. Ажил эрхлэлтийн хувь болон үйлдвэрүүдийн үйл ажиллагаа хэвийн үеийн түвшиндээ хүрээд байгаа хэдий ч, гадаад эрэлт саарсан, дотоод эрэлт нэмэгдээгүй байгаа тул гадаад худалдаа эрхэлдэг жижиг ААН-үүд хүндрэлтэй хэвээр байна.
- **Хятадын боловсруулах салбарын худалдан авагч менежерүүдийн индекс (PMI индекс) 3-р сард 52.0 байсан бол 4-р сард 50.8 болж буурав.** Дэлхийн эдийн засаг удааширсан нь ийнхүү Хятадын аж үйлдвэрлэлд тусгалаа олж байна. Харин боловсруулах бус салбарын (non-manufacturing) PMI индекс өмнөх сард 52.5-оос 4-р сард 53.2 болж өсчээ.
- Автомашинууд худалдаа оны эхний 2 сард 81.7 хувиар буурсан бол, 3-р сараас уналт саарч 48.4 хувь, 4-р сарын 19-ний байдлаар 7 хувиар тус тус буурчээ.
- **Хятадын дотоодын хөрөнгө оруулалт алгуур сэргэж байна.** Хятадын Хөгжил

Шинэтгэлийн Хороо 2 болон 3-р сард нийт 189.8 тэрбум юанийн дэд бүтцийн төслүүдийг баталсан нь өмнөх оны мөн үе (32.3 тэрбум юань)-тэй харьцуулахад өндөр өсөлт байв. Үүний нөлөөгөөр оны эхний 2 сард 30.3 хувиар буураад байсан дэд бүтцийн хөрөнгө оруулалтын агшилт саарч, 1-р улиралд 19.7 хувийн агшилттай гарав. Үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалт оны эхний 2 сард 18.1 хувиар буурч байсан бол, 1-р улиралд 9.3 хувиар буурчээ. Барилгын салбарт ашиглагддаг гангийн худалдаа 2019 оны 4-р улирлын хэмжээнд хүрсэн, гангийн нөөц 5 дахь долоо хоногтоо буурсан, барилгын салбарын машин, мэханизмын худалдаа 3-р сард 11.6 хувиар нэмэгдсэн нь барилгын салбарт сэргэлт алгуур гарч байгааг илтгэж байна.

- **Хятадын коксжих нүүрсний нийт импорт 3-р сард 27.8 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 18.5 хувиар нэмэгдлээ.** БНХАУ-ын Австралиас импортлосон коксжих нүүрсний хэмжээ өмнөх оны мөн үеэс 2 дахин нэмэгдэж 3-р сард 4.37 сая тоннд хүрсэн, АНУ-аас импортлосон коксжих нүүрсний хэмжээ 60.6 мянган тонноос 133.6 мянган тоннд хүрч нэмэгдсэн бол Монгол Улсаас импортлосон нүүрсний хэмжээ 3.26 сая тонноос 49.6 мянган тонн, ОХУ-аас импортлосон нүүрсний хэмжээ 417.6 мянган тонноос 369.9 мянган тонн болж тус тус буурав.

- КОВИД-19-ээс шалтгаалан эрэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаа тул коксжих нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ болон Хятадын эрчим хүчний нүүрсний үнэ бага түвшинд хадгалагдсан хэвээр байгааг SXCoal 4-р сарын 24-ны тоймдоо мэдээлэв. Энэ оны 2-р улиралд дэд бүтцийн төслүүд эхэлснээр, гангийн эрэлт нэмэгдэж Хятадын гангийн жилийн үйлдвэрлэл өмнөх оны түвшинд хүрэх хүлээлттэй байна.
- **Хятадын төсвийн бодлого:** Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бонд олголт болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх (local government debt sales) зэрэг арга хэмжээ авснаар ойролцоогоор 2020 онд 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийхээр байна. **Хятадын Ардын Их Хурлын тов зарлагдаж, 5-р сарын 22-ний өдөр хуралдахаар болов.** Энэ нь Хятадын Засгийн газар КОВИД-19 өвчлөлийн тархалтыг бүрэн хяналтдаа оруулах эерэг дохио болж, эдийн засаг оны 2-р хагаст “V” хэлбэртэй сэргэлт үзүүлэх боломж нэмэгдэж байна. Энэхүү хурлаар Хятадын Засгийн газар ДНБ-ий өсөлт, мөнгөний нийлүүлэлт, инфляцийн зорилт болон төсвийн төслөө баталдаг бөгөөд эдийн засгийн сэргээхэд дэмжлэг үзүүлэх хэд хэдэн бодлогын чиглэлүүдийг батална. Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай

Засгийн газрын бондын квотын хэмжээг нэмэгдүүлэх хүлээлттэй байна. Хятадын Сангийн яамнаас эдийн засгийг дэмжих хүрээнд 3-р сард 0.29 их наяд юанийн орон нутгийн тусгай зориулалттай бондыг 2020 онд зориулан батлаад байна. Хятадын бодлогын хороо нь тусгай зориулалттай бондын батлах дээд хэмжээндээ хүрсэн тул нэмэлт квотыг хэмжээг 5-р сарын Ардын Их Хурлаараа батлахаар байна.

- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Банк (ХАБ) энэ онд бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулахаар байгаа бөгөөд 2-р сараас хойш бодлогын хүүг 0.3 нэгж хувиар бууруулж нэг жилийн хугацаатай дунд хугацааны зээлийн хүүг (TMLF) 3.15 хувиас бууруулж, 2.95 хувьд хүргээд байна. Энэхүү зээлийн хүү нь 2018 оны 12-р сараас хойш 3.15 хувьд хадгалагдаж байсан юм. Түүнчлэн ХАБ хугацаа нь дуусч буй 267.4 тэрбум юанийн дунд хугацааны зээлийг дахин сунгав. ХАБ-наас 1.8 их наяд юанийн квотыг банкуудад дахин зээлдүүлэх нөхцөлийг бүрдүүлээд буй тул дунд хугацааны зээлийн (TMLF) эрэлт харьцангуй бага хадгалагдахад нөлөөлжээ. Мөн цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна.

3 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ГОЛЛОХ ИНДЕКС ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

USD, Dow Jones, S&P:

- ХНБ-наас актив худалдан авалтаа үргэлжлүүлэн, зах зээлийн хөрвөх чадвар буурахаас сэргийлж мөнгө нийлүүлсээр байна.
- ЗГ-ын зүгээс төсвийн удаа дараагийн дэмжлэг үзүүлж буй нь хөрөнгийн зах зээлд эерэг дохио болсноор хувьцааны индексүүд өмнөх сараас 14-19%-иар сэргэлээ.
- АНУ-ын эдийн засаг 2020 оны I улиралд улирлын дүнгээр 4.8%-иар агшиж, ажилгүйдлийн түвшин 4.4% хүрч өсөөд байна.

EUR:

- Өнгөрсөн 14 хоногийн хугацаанд хугацаанд евро ам.долларын эсрэг 1.1%-иар чангарч, 1.10 түвшинд хүрэв.
- КОВИД-19 вирусийн нөлөөгөөр Евро бүсийн эдийн засаг 2020 оны I улиралд жилийн дүнгээр 3.3, улирлын дүнгээр 3.8 хувь агшлаа. Энэ үзүүлэлт нь Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас хойш тохиолдсон хамгийн муу үзүүлэлт болов.

CNY:

- Өнгөрсөн 14 хоногийн хугацаанд юань ам.долларын эсрэг 0.3%-иар чангарч, 7.06 түвшинд хүрлээ.

- Хөрвөх чадварыг хангах шалтгаанаар ХАБ-ны зүгээс юанийн ханшийн хэлбэлзлийг нам дор байлгахыг зорьж байна.
- БНХАУ-ын эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж эхэлснээр хувьцааны индекс сарын өмнөх үеэс 1.5%-иар өслөө.

JPY, Nikkei:

- Өнгөрсөн 14 хоногийн хугацаанд хугацаанд иен ам.долларын эсрэг 0.7%-иар чангарч 107.18-т хүрэв.
- 4-р сараас эхлэн орон даяар хөл хорио хэрэгжүүлж эхэлсэн тус улсад вирусийн дэгдэлт харьцангуй бага байгаа хэдий ч 2020 онд ДНБ 4%-иар буурах төсөөлөлтэй байна.

GBP, FTSE:

- 14 хоногийн хугацаанд фунт стерлинг нь ам.долларын эсрэг 1.1%-иар чангарч, 1.26 түвшинд хүрлээ.
- Их Британи улс хорио цээрийн дэглэмд шилжсэн хэвээр байна. ЗГ-ийн зүгээс эдийн засгийн идэвхижилтийг дэмжих бодлогын хүрээнд ЖДҮ-д хөнгөлөлттэй зээл олгохоор бэлтгэл ажлыг хангаад байна.

Хүснэгт 1: Голлох индексийн хөдөлгөөн

Индекс	Сүүлийн хаалт	14 хоног Δ /% /	1 сар Δ /% /	1 жил Δ /% /	Оны эхнээс Δ /% /
Dow Jones	24345.7	▲ 3.4%	▲ 13.7%	▼ -8.3%	▼ -15.7%
S&P	2912.4	▲ 4.0%	▲ 15.3%	▼ -0.9%	▼ -10.6%
NASDAQ	8889.6	▲ 4.2%	▲ 18.7%	▲ 9.3%	▼ -2.2%
Hang Seng	24643.6	▲ 2.7%	▲ 5.9%	▼ -16.8%	▼ -13.7%
Nikkei	20193.7	▲ 4.7%	▲ 13.3%	▼ -9.3%	▼ -13.0%
FTSE 100	5901.2	▲ 4.8%	▲ 7.7%	▼ -20.6%	▼ -22.4%
EURO S50	2927.9	▲ 4.1%	▲ 8.9%	▼ -16.4%	▼ -22.8%

Хүснэгт 2: Голлох ханшийн хөдөлгөөн

Валют	Сүүлийн хаалт	14 хоног Δ /% /	1 сар Δ /% /	1 жил Δ /% /	Оны эхнээс Δ /% /
EUR-USD	1.10	▲ 1.1%	▲ 0.9%	▼ -1.8%	▼ -2%
GBP-USD	1.26	▲ 1.1%	▲ 1.6%	▼ -2.5%	▼ -4%
USD-JPY	107.18	▼ -0.7%	▼ -0.7%	▼ -3.9%	▼ -1%
AUD-USD	0.65	▲ 2.9%	▲ 7.4%	▼ -7.5%	▼ -7%
USD-CNY	7.06	▼ -0.3%	▲ 0.6%	▲ 5.0%	▲ 1%
EUR-GBP	0.87	▼ 0.0%	▼ -0.7%	▲ 0.8%	▲ 2%
EUR-JPY	117.42	▲ 0.4%	▲ 0.2%	▼ -5.7%	▼ -3%

ХҮҮ, БОНД БОЛОН ОЛОН УЛСАД АРИЛЖААЛАГДАЖ БУЙ МОНГОЛ УЛСЫН БОНД, ХУВЬЦААНЫ ӨӨРЧЛӨЛТ**Лондонгийн банк хоорондын захын хүү (LIBOR):**

Мөнгөний нийлүүлэлтээс үүдэн тайлант хугацаанд 6 сар хүртэлх LIBOR хүү 13 хүртэл суурь нэгж буурсан бол 12 сарын хүү 3 суурь нэгжээр буурав..

АНУ-ын ЗГҮЦ:

АНУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 3 суурь нэгжээр буурсан бол 2 жилтэй үнэт цаасны өгөөж 0.22 хувьд буюу түүхэн доод түвшинд хэвээр байв. ХНБ нээлттэй зах зээлээс ЗГҮЦ худалдан авах хэмжээг өдрийн 15 тэрбумаар бууруулах тухай мэдэгдсэн, төсвийн зардал огцом нэмэгдэж байгаа зэргээс хамаарч үнэ унах, өгөөж өсөх хүлээлт үүсгээд байна.

Шанхайн банк хоорондын захын хүү (SHIBOR):

Тайлант хугацаанд SHIBOR хүү КОВИД-19 тархалтаас хойш үргэлжлэн буурлаа. Овернайт хүү 0.91% буюу 1%-аас доош түвшинд хүрэв. 4-р сарын хагасаас эхлэн хүүний уналт удааширч, тогтворжих хандлагатай байна.

Бондын мэдээлэл:

Монгол Улсын гадаад зах зээлд гаргасан үнэт цаасны үнэ буурч, жилийн өгөөж 11.1 хувь хүртэл өсөв. ХХБ-ны ҮЦ-ны дуусах хугацаа ойртож байгаа, хөрөнгө оруулагчид зээлийн эрсдэлээс зугтаах үйл явц ажиглагдаж байгаа зэрэг нь тус бондын өгөөж өсч 17.9 хувьд хүрэхэд голлон нөлөөлөв.

Хүснэгт 3: Дотоодын үнэт цаасны өөрчлөлт

Индекс	Сүүлийн хаалт		14 хоног Δ		1 сар Δ		1 жил Δ		Оны эх Δ
Fed Overnight	0.05	▲	0.00	▼	-0.20	▼	-2.36	▼	-1.50
Libor 1 week	0.17	▼	-0.04	▼	-0.23	▼	-2.26	▼	-1.42
Libor 1 month	0.62	▼	-0.13	▼	-0.36	▼	-1.86	▼	-1.11
Libor 3 month	1.04	▼	-0.09	▼	-0.33	▼	-1.54	▼	-0.86
Libor 6 month	1.02	▼	-0.13	▼	-0.18	▼	-1.59	▼	-0.89
Libor 12 month	0.99	▼	-0.03	▼	-0.07	▼	-1.73	▼	-1.01
Shibor O/N	0.91	▲	0.21	▼	-1.59	▼	-1.17	▼	-0.53
Shibor 1 Week	1.72	▲	0.06	▼	-0.89	▼	-0.97	▼	-0.72
Shibor 1 Month	1.30	▼	-0.02	▼	-1.50	▼	-1.55	▼	-1.60
Shibor 6 Month	1.49	▼	-0.03	▼	-1.42	▼	-1.48	▼	-1.53
Shibor 1 Year	1.68	▼	-0.01	▼	-1.30	▼	-1.48	▼	-1.40
US 2Y Treasury	0.22	▲	0.02	▼	0.00	▼	-2.06	▼	-1.34
US 10Y Treasury	0.60	▼	-0.03	▲	0.00	▼	-1.90	▼	-1.28
Japan 2Y Treasury	-0.16	▲	0.00	▼	-0.04	▼	-0.01	▼	-0.03
Japan 10Y Treasury	-0.03	▼	-0.03	▼	-0.01	▲	0.02	▼	-0.01
Bund 2Y Treasury	-0.72	▼	-0.02	▼	-0.05	▼	-0.11	▼	-0.10
Bund 10Y Treasury	-0.48	▲	0.00	▼	-0.04	▼	-0.45	▼	-0.25
EONIA	-0.46	▼	-0.01	▼	-0.01	▼	-0.09	▼	0.00

5 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Улсын Их Хурлын 2020 оны 4-р сарын 29-ны чуулганы нэгдсэн хуралдаанаар “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа.

Уг тогтоолд Монгол Улсын урт хугацааны тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлж, үүсэх эрсдэлээс хамгаалж, санхүүгийн чадвартай байх эрүүл, тогтвортой, зохистой засаглал бүхий банкны салбарыг бий болгох шинэчлэлийн хөтөлбөрийг гаргаж, хэрэгжүүлэх, зээл, санхүүжилтийн хүү болон эх үүсвэрийн зардлыг бууруулах, цар тахлын үед төрөөс нийгмийн шаардлагатай хэсэгт хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, жижиг дунд үйлдвэрийн зээлд батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх

болон улсын гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, мөнгө хүүлэлтийг хязгаарлах замаар зээлдэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг нэн яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд багтсан юм. Түүнчлэн, төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах хүрээнд түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ноолуурын түүхий эдийн экспорт бүрдүүлэх, ноолуурын экспортыг дэмжих зорилгоор хилээр татваргүй гаргах, хөнгөлөлттэй зээл олгох, малчдын орлого болон үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зорилгоор ноолуурын килограммын суурь үнэ дээр нэг килограмм тутамд 20 мянган төгрөгийн урамшууллыг малчин бүрт олгох зэрэг заалтууд уг тогтоолд орсон.